



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

“Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн  
2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот  
түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн  
гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал Д.Лхам-Оролмаатай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Д.Лхам-Оролмаатай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3.“Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн тул Гүйцэтгэх захирал Д.Лхам-Оролмаад хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4. Гүйцэтгэх захирал Д.Лхам-Оролмаад хавсралтын дагуу олгох урамшууллыг холбогдох эх үүсвэрээс гаргахыг “Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Ерөнхий санхүүч С.Төмөрбаатарт зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлагыг, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001312

11-r huraldaan.docx

ТӨРИЙНӨМЧИИН БОДЛОГОГОД ЗОХИЦУУЛАЛТЫН  
газарын 2024 оны 04 дугаар сарын 18-ны  
өдрийн 16:00 дугаар тогтооплын хавсралт

"ӨВӨРХАНГАЙ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛД 2023 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

/төгрөгөөр/

Д/Д	Хуулийн этгээдийн нэр	Гүйцэтгэх захирлын нэр	Цэвэр ашиг	Цэвэр ашигийн дүнгээс хасаж тооцох валютын ханшийн өөрчлөлтөөс олсон ашиг алдагдал	Урамшуулалт тооцох цэвэр ашиг	Олгох урамшууллын хэмжээ
1	"Өвөрхангай АЗЗА" ТӨХК	Д.Лхам-Оролмаа	77,769,784.30	-	77,769,784.30	6,555,400.00 (Зургаан сая таван зуун тавин таван мянга дөрвөн зуун төгрөг)